



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ
ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА**

Улаанбаатар хот
2023 он

АГУУЛГА

Хуудасны
дугаар

УДИРТГАЛ

НЭГ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ,
САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

4-5

ХОЁР.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛИАР
ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

5-11

2.1. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх бүрэн эрхийн хүрээнд

2.2. Нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих хүрээнд

2.3. Нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх, нийгмийн даатгалын салбарыг цахимжуулах хүрээнд

2.4. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд

2.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар түүнд хяналт тавих хүрээнд

2.6. Нийгмийн даатгал, эмнэлэг хөдөлмөрийн магадлагааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах хүрээнд

ГУРАВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

11-15

3.1. Нийгмийн даатгалын сангийн орлого

3.2. Нийгмийн даатгалын сангийн зарлага

ДӨРӨВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ӨР АВЛАГЫГ
БАРАГДУУЛАХ ХҮРЭЭНД

15-18

4.1. Капитал банкны өр авлагыг барагдуулах хүрээнд

4.2. Чингис хаан банк болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкны өр авлагыг барагдуулах хүрээнд

ТАВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ НЬ ҮЙЛ
АЖИЛЛАГААНДАА СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ
ТАЛААР

18-20

ЗУРГАА.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

20-21

Хүснэгт, зураг

Хүснэгт 1.Нийгмийн даатгалын салбарын зарим үзүүлэлтүүд

Хүснэгт 2.Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн

Хүснэгт 3.Нийгмийн даатгалын сангийн 2022 оны орлого, зарлага

Хүснэгт 4.Нийгмийн даатгалын сангийн зарлага

Хүснэгт 5.Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тэрбум.төг

Хүснэгт 6.Аудитын зөвлөмж, шаардлагын хэрэгжилт

Хүснэгт 7.Хөрөнгийн мэдээлэл

Хүснэгт 8.ЭМДЕГ-тай хамтран эзэмшиж буй хөрөнгө

Хүснэгт 9.Капитал банкнаас авах авлага болон дансны үлдэгдэл

Зураг 1.Нийгмийн даатгалын хамралт, даатгуулагчдын тоо

Зураг 2.Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдэлт

Зураг 3.Нийгмийн даатгалын сангийн 2021-2022 оны батлагдсан төсөв

Зураг 4.Нийгмийн даатгалын сангийн зарлага

Хавсралт

Хавсралт 1.Нээлттэй дуудлага худалдааны мэдээлэл

Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
НДҮЗ	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар
НДБ	Нийгмийн даатгалын байгууллага
НДС	Нийгмийн даатгалын сан
НДХ	Нийгмийн даатгалын хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАНД ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН ТАЛААРХ ТАНИЛЦУУЛГА

2023 оны 05 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

УДИРТГАЛ

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1-д “Улсын Их Хурал нь Засгийн газар, даатгуулагч, ажил олгогчийг тэнцүү тоогоор төлөөлсөн орон тооны бус гишүүдээс бүрдсэн Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийг байгуулж ажиллуулна. Үндэсний зөвлөл ажлаа Улсын Их Хуралд тайлагнана.” гэж заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл /цаашид “НДҮЗ” гэх/ 2022 оны үйл ажиллагааны тайлангаа 2023 оны 05 дугаар сарын 01-ний өдрийн 33 дугаар албан бичгээр Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлсэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, мөн Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолд заасны дагуу “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайлан” болон “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайлан”-д шинжилгээ хийлгээ.

Тайланд шинжилгээ хийхдээ Нийгмийн даатгалын тухай хууль, НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны болон системчилсэн үнэлгээний тайлан, Нийгмийн даатгалын сангийн 2021, 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, НДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн талаарх Нийгмийн бодлогын байнгын хорооны 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны тэмдэглэл¹, Үндэсний статистикийн хорооноос гаргадаг нийгмийн даатгалын үзүүлэлтүүд зэрэгт тулгуурлан баримт бичгийн болон статистик шинжилгээний арга зүйг ашиглалаа. Мөн НДҮЗ-ийн ажлын албаны холбогдох ажилтантай утсаар болон цахим шуудангаар холбогдож, шаардлагатай мэдээлэл, нэмэлт тодруулга, тайлбарыг авч ажиллалаа.

НДҮЗ нь 2022 онд Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйл болон Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо (Хуучин нэрээр)-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-д заасан бүрэн эрх, чиг үүргээ хэрэгжүүлсэн байдал, Нийгмийн даатгалын сангийн төсөв, түүний зарцуулалт болон Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийж ажилласан байдал, Байнгын хорооноос өгсөн үүргийн хэрэгжилт гэсэн агуулгын хүрээнд шинжилгээ хийж, танилцуулга бэлтгэн хүргүүлж байна.

¹Монгол Улсын Их Хурлын 2022 оны хаврын ээлжит чуулганы НББХ-ны 05 дугаар сарын 04-ний өдөр /лхагва гараг/-ийн хуралдааны тэмдэглэл (НДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцсэн тухай)

НЭГ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САЛБАРЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Манай улсын ажиллах хүчний 82.2 орчим хувь нь нийгмийн даатгалд даатгуулж, жилд дунджаар давхардсан тоогоор 700.0 мянга гаруй хүн нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авч байна. 2022 оны байдлаар 772.4 мянган хүнд нийгмийн даатгалын үйлчилгээг үзүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 3,311.8 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тайлант хугацаанд нийгмийн даатгалд 1,269,375 даатгуулагч даатгуулсан нь өнгөрсөн оноос 7.7 хувиар нэмэгдсэн бөгөөд 1,104,870 даатгуулагч буюу нийт даатгуулагчдын 87.0 хувь нь албан журмын, үлдсэн 164,505 буюу 13.0 хувь нь сайн дурын даатгуулагчид байна. Нийгмийн даатгалд даатгуулагчдын 80-аас дээш хувь нь албан журмын даатгалд хамрагдаж, энэ нь нийт ажиллах хүчний 90.3 хувийг эзэлж байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалд хамрагдсан ажил олгогчийн тооны өсөлт өмнөх оноос 5.1 хувиар өсөж 55.5 мянгад хүрсэн байна.

Зураг 1. Нийгмийн даатгалын хамралт, даатгуулагчдын тоо



Зураг 1-т албан журмын даатгуулагчид ерөнхийдөө тасралтгүй өсөж, харин сайн дурын даатгуулагчдын тоо 2016-2019 онуудад буурч, бусад онуудад хэлбэлзэлтэй байна. 2022 онд сайн дурын даатгуулагчдын тоо өмнөх оноос өссөн хэдий ч сайн дурын даатгуулагчдаас төвлөрүүлсэн орлого 2021 оноос 25.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.

2022 оны байдлаар Нийгмийн даатгалын сан /цаашид “НДС” гэх/-аас 473.8 мянган иргэн тэтгэвэр авч байгаагийн 79.5 хувь нь өндөр насны, 10.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.4 хувь нь тэжээгчээ алдсаны, 6.6 хувь нь цэргийн тэтгэвэр авч байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангийн зарлага дотоодын нийт бүтээгдэхүүний 5.9 хувь, төсвийн зарлагын 17.3 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Нийгмийн даатгалын салбарын зарим үзүүлэлтүүд

Үзүүлэлт	2016 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Нийт тэтгэвэр авагчдын тоо	371,340	418,379	449,178	460,562	473,800
Тэтгэвэр авагчид/нийт хүн ам (%)	12.1%	13.0%	13.8%	13.9%	14.1%
Тэтгэвэр авагчид/ажиллах хүч (%)	29.1%	32.8%	35.9%	37.6%	37.4%
Тэтгэврийн даатгалын сангийн зарлага (сая.төгрөг)	1,330.6	1,864.3	2,178.8	2,304.4	3,031.3
Тэтгэврийн даатгалын сангийн зарлага/ДНБ (%)	5.5%	4.9%	5.8%	5.3%	5.9%
Тэтгэврийн даатгалын сангийн зарлага/Төсвийн зарлага (%)	13.9%	15.8%	15.6%	14.7%	17.3%

Эх сурвалж: УСХ, Сангийн яам

2022 оны тэтгэврийн даатгалын сангийн зарлагыг 2016 онтой харьцуулахад 2.3 дахин өсөж, төсвийн зарлагад эзлэх хувь 13.9-17.3 хувь болж 3.4 пунктээр нэмэгдсэн байна. 2022 оны байдлаар тэтгэврийн даатгалын сангаас 473.8 мянга гаруй хүн тэтгэмж авч байгаа нь нийт хүн амын 14.1 хувь, ажиллах хүчний 37.4 хувьтай тэнцэж байна.

Нийгмийн даатгалын сангийн зарцуулалтыг авч үзвэл, тэтгэврийн даатгалын сангийн зарлага хамгийн өндөр хувийг эзэлж байгаа бөгөөд 2022 оны жилийн эцсийн байдлаар тэтгэврийн даатгалын сангийн зарлага өмнөх оны гүйцэтгэлээс 850.2 тэрбум төгрөг буюу 33.1 хувиар өсөж 3,031.3 тэрбум төгрөгт хүрчээ. Энэ нь НДС-ийн нийт зарлагын 88.7 хувийг эзэлж байна. Нийт өндөр насны тэтгэвэр авагчдын 7.9 хувь нь хувь тэнцүүлсэн тэтгэвэр, 92.1 хувь нь бүрэн тэтгэвэр авч байна.

ХОЁР.НИЙГМИЙН ДААТГАЛЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН ХУУЛИАР ХҮЛЭЭСЭН ЧИГ ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ

НДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйл болон Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хороо (хуучин нэрээр)-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дүрэм”-д заасан бүрэн эрх, чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлт болон нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэлд хяналт тавих, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах үйл ажиллагааны талаарх холбогдох шийдвэр гаргах, нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардлын төсвийн төсөл, төсөөлөл, төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх, гүйцэтгэлд нь хяналт тавих, нийгмийн даатгалын асуудлаар тогтоол, журам, зөвлөмж, аргачлал, чиглэл гаргах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлдэг.

НДҮЗ-ийн хуулиар хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг дараах агуулгын хүрээнд шинжилгээ хийсэн болно. Үүнд:

2.1.Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомж, нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааг боловсронгуй болгох, нийгмийн даатгалын төв байгууллагын бүтцийг батлах, тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх бүрэн эрхийн хүрээнд:

Нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоо нь НДҮЗ, Ажлын алба, Нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүрэг, БНСУ дахь Нийгмийн даатгалын газар, хэлтэс, тасаг, Нийгмийн даатгалын байцаагч, ажилтнаас бүрдэж байна.

Засгийн газрын 2017 оны “Агентлаг байгуулах тухай” 344 дүгээр тогтоол, НДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын “Нийгмийн даатгалын ерөнхий газрын бүтэц, орон тоог батлах тухай” 2018 оны А/25 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага Нийгмийн даатгалын ерөнхий газар /цаашид “НДЕГ” гэх/ нь 6 газар, 5 хэлтэс, дэргэдээ 2 төвтэй, нийт 111 албан хаагчидтай, аймаг, нийслэл, дүүргийн 31 газар, хэлтэст Нийгмийн даатгалын бодлогын хэрэгжилтийг хангах, Нийгмийн даатгалын үйлчилгээг иргэд даатгуулагчдад үзүүлэх чиг үүрэг бүхий 1,293, салбарын хэмжээнд нийт 1,416 албан хаагч, улсын байцаагчидтайгаар үйл ажиллагаагаа явуулж байна. НДҮЗ-ийн Ажлын алба нь Улсын Их Хурлын НББСШУБХ-ны 2018 оны 19 дүгээр тогтоолоор батлагдсан 12 орон тоотойгоор чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрыг төлөөлсөн 3 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 3 гишүүн, даатгуулагчийг төлөөлсөн 3 гишүүнээс бүрддэг бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга, гишүүдийг талуудын санал болгосноор Улсын Их Хурал нэр дэвшигчийн сонсгол хийж зургаан жилийн хугацаагаар томилдог.

2022 онд НДҮЗ-ийн даатгуулагчийг төлөөлсөн 2 гишүүн, ажил олгогчийг төлөөлсөн 1 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан Нийгмийн бодлогын байнгын хороо Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 31 дүгээр зүйл, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 123, 126 дугаар зүйлийг баримтлан нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулж, Улсын Их хурлын 2022 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 50 дугаар тогтоолоор гишүүдийг тус тус томилсон.

Харин даатгуулагчийг төлөөлсөн 1 гишүүний бүрэн эрхийн хугацаа 2022 оны 12 дугаар сарын 08-ны өдөр дуусгавар болсон байна.

НДҮЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан бөгөөд 2022 онд нийт 8 удаагийн хуралдаан зохион байгуулж, нийт 17 асуудлыг хэлэлцэж, 7 тогтоол гаргасан байна. Эдгээр тогтоолуудаас “Оршуулгын тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоо тухай” болон “Нэрийн дансны 2022 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоо тухай” 2 тогтоолыг баталж, Захиргааны ерөнхий хуулийн дагуу нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгүүлжээ.

Түүнчлэн нийгмийн даатгалын байгууллага нь эрсдэлийг урьдчилан тооцоолох, хянах, удирдах, үр дүнтэй хэрэгжүүлэх зорилгоор НДЕГ-ын Дотоод аудит, мониторингийн газарт Эрсдэлийн удирдлагын нэгжийг байгуулах, хяналт шалгалтын нэгжийг өргөжүүлж цахим хяналтын нэгжийг байгуулах зэргээр Нийгмийн даатгалын салбарт бүтцийн өөрчлөлт хийх шаардлагатай байгаа талаар 2021 оны үйл ажиллагааны тайланд тусгасан байсан хэдий ч 2022 онд нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр тодорхой өөрчлөлт хийгдээгүй байна.

Нийгмийн даатгалын ерөнхий хууль болон Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, Мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Хувийн нэмэлт тэтгэврийн тухай хуулиудаас бүрдсэн Нийгмийн даатгалын багц хуулийн төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, хуулийн төсөл хэлэлцүүлгийн шатанд байна.

Тайлант хугацаанд НДС-ийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төрийн хэмнэлтийн тухай хууль;
- Нийгмийн даатгалын шимтэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Журам батлах тухай” 230 дугаар тогтоол;
- НДЕГ-ын даргын 2022 оны А/64 дугаар тушаалаар “Нийгмийн даатгалын” нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-ийг шинэчлэн баталсан байна.

Тэтгэвэр нэмэгдүүлэх талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх:

Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоол батлагдсаны дагуу тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулж, НДС-аас болон цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар тус тус нэмэгдүүлж, бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоожээ. Ингэснээр нэмэгдсэн тэтгэврийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн олгож, нийт 469.2 мянган тэтгэвэр авагчид тэтгэврийн нэмэгдэлд 637.4 тэрбум төгрөг зарцуулан дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрчээ.

Энэхүү арга хэмжээний дунд 469.2 мянган хүний тэтгэвэр дунджаар 130.8 мянган төгрөгөөр, үүнээс бүрэн тэтгэвэр авч байсан 385.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 150.0 мянган төгрөгөөр, хувь тэнцүүлсэн тэтгэвэр авч байсан 84.1 мянган хүний тэтгэвэр дунджаар 100.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, дундаж тэтгэвэр 424.8 мянган төгрөгөөс 555.6 мянган төгрөгт хүрч, дунджаар 130.8 мянган төгрөгөөр буюу 30.8 хувиар нэмэгдсэн байна. Нийт тэтгэвэр авагчдын 58.1 хувь нь (доод хэмжээ) 350000 төгрөгийн тэтгэвэр авч байсан бол тэтгэвэр нэмэгдүүлэх арга хэмжээний дараа тэтгэвэр авагчдын 76.1 хувь нь (доод хэмжээ) 500000 төгрөг авдаг болжээ.

Тэтгэвэр нэмэгдүүлэх шийдвэр гарахаас өмнө бүрэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (350001-435000 төгрөг) тэтгэвэр авч байсан 75.4 мянган хүн, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээнээс дээш (300001-348000 төгрөг) тэтгэвэр авч байсан 4.4 мянган хүн, нийт 79.8 мянган хүний тэтгэврийн доод хэмжээг 500000 төгрөг болгон өөрчлөн тогтоосон байна.

Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор “НДС-аас олгож байгаа болон цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэхэд баримтлах заавар”-ыг боловсруулан аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст хүргүүлж, тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2022 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 9.8 хувиар тогтоожээ.

Мөн НДҮЗ-ийн 2022 оны 04 дүгээр тогтоолоор Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 21¹ дүгээр зүйл, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 24 дүгээр зүйл, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны саналыг тус тус үндэслэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу оршуултын тэтгэмжийн болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан нас барагчийн ар гэрт олгох тэтгэмжийн хэмжээг **хоёр сая** төгрөгөөр шинэчлэн, амьгүй донор болж эс, эд, эрхтнээ бусдад шилжүүлсэн даатгуулагчийн ар гэрт олгох оршуулгын тэтгэмжийн хэмжээг **гурван сая таван зуун** мянган төгрөгөөр тус тус тогтоож, 2023 оны 01 дүгээр сарын 01-ээс мөрдөж байна.

2.2.НДС-ийн төсвийн төслийг боловсруулах, батлагдсан төсвийн нарийвчилсан хуваарийг баталж, гүйцэтгэлд нь хяналт тавих хүрээнд:

НДҮЗ-ийн 2022 оны 02, 03, 05 дугаар тогтоолуудаар 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг тус тус үндэслэн тэтгэвэр авагчдын тэтгэврийн нэмэгдэлд зарцуулахаар батлагдсан хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах хөрөнгийг тэтгэврийн даатгалын сангийн өмнөх оны төлөвлөгөөнөөс давсан орлогоос буюу харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2022 оны НДС-ийн болон аймаг,

дүүргийн НДС-ийн төсвийн хуваарыт 3 удаа холбогдох өөрчлөлтүүдийг оруулж, тодотгосон төсвийн хуваарийг шинэчлэн баталж, мөрдүүлсэн байна.

НДҮЗ-ийн 2022 оны 06 дугаар тогтоолоор Нийгмийн даатгалын сангийн 2023 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.6 дахь заалтыг үндэслэн тэтгэвэрт зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 214.5 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын сангийн, ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжид зарцуулах хөрөнгийн эх үүсвэрт шаардагдах 24.4 тэрбум төгрөгийг ажилгүйдлийн даатгалын сангийн харилцахын мөнгөн хөрөнгөөс зарцуулахыг НДЕГ-т зөвшөөрч, 2023 оны НДС-ийн болон аймаг, дүүргийн НДС-ийн төсвийн хуваарийг баталжээ.

2.3. Нийгмийн даатгалын байгууллагын цахим тооцоолуурын техник, технологи, программ хангамж, үйлчилгээний байдлыг хянаж үнэлэлт дүгнэлт өгөх, нийгмийн даатгалын салбарыг цахимжуулах хүрээнд:

2022 онд холбогдох хууль тогтоомжид оруулсан нэмэлт, өөрчлөлт болон хэрэглэгчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу нийгмийн даатгалын үйлчилгээнд шинээр 3 систем, 15 сервис үйлчилгээг нэвтрүүлж, программ хангамжуудад 110 гаруй удаагийн өөрчлөлтийг оруулж, төрийн үйлчилгээний 109 ТҮЦ машинаар үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэн даатгуулагч 2000-2005 оны нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоо авах боломжийг нэмж бүрдүүлсэн байна.

Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санд 55.4 мянган ажил олгогч, 1,104.8 мянган албан журмын, 164.5 мянган сайн дураар даатгуулагч, 473,8 мянган тэтгэвэр авагчийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий 74GB мэдээлэл агуулагдаж байна. Төрийн мэдээлэл солилцооны ХҮР системээр дамжуулан 18 байгууллагатай холбогдох мэдээллийг солилцож, төрийн цахим үйлчилгээний нэгдсэн портал "E-Mongolia"-д 5 төрлийн сервисийг шинээр боловсруулан хүргүүлсэн зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Нийгмийн даатгалын нийт 34 үйлчилгээний 18 үйлчилгээг 2021 онд цахимжуулаад байсан бол 2022 онд 6 үйлчилгээг нэмж, нийт 24 үйлчилгээ бүрэн цахимжуулж, ингэснээр нийгмийн даатгалын үйлчилгээний 70.6 хувь нь цахимжаад байна. Цахимжуулалтын хүрээнд нийгмийн даатгалын болон тэтгэврийн дэвтрийг цахим хэлбэрт бүрэн шилжүүлж, цахимжуулсан үйлчилгээнээс 16 үйлчилгээг сонгож хэмнэлтийн судалгааг хийхэд 1 жилд 12.4 тэрбум төгрөгийг даатгуулагч, иргэд, ажил олгогч хэмнэсэн гэсэн тооцоо гарсан байна. Цахимжуулалтыг нэвтрүүлснээр нийгмийн даатгалын үйлчилгээ түргэн шуурхай, ил тод, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх боломжийг бүрдүүлсэн байна.

2.4. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих чиг үүргийн хүрээнд:

2022 онд Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймаг, Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс /цаашид "НДХ" гэх/-ийн 2017-2021 оны санхүүгийн баримт бичгүүдэд хяналт шалгалт хийжээ. Шалгалтын явцад 1,929.9 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 698.5 сая төгрөгийн төлбөрийг нөхөн төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоосноос 81.9 хувийг барагдуулсан байна. Дээрх шалгалтаар дараах нийтлэг зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Хууль бус, үндэслэлгүй баримтаар 86 иргэнтэй холбоотой 1,834.0 сая төгрөгийг шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулж хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгосон;
- 103 иргэнд 61.9 сая төгрөгийг байцаагчийн алдаанаас болж илүү тооцож олгосон, 50 иргэнд 44.8 сая төгрөгийг дутуу олгосон;

- Ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд 29.6 сая төгрөгийг үндэслэлгүйгээр олгосон, 1 хүнд 1.1 сая төгрөгийг дутуу олгосон;
- Баянзүрх дүүргийн НДХ-т хийгдсэн шалгалтаар нийт 27.5 сая төгрөгийн үндэслэлгүй баримтаар зардал гаргасан, түрээсийн орлогыг хуулийн дагуу төвлөрүүлэхгүй, нярав, нягтлан бодогч нарын хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн зэрэг зөрчлүүд гарч байна.

Хүснэгт 2.Хяналт, шалгалтаар илэрсэн зөрчлийн дүн

№	2021 онд шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн НДХ	Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн /сая төг/	2022 онд шалгалтад хамрагдсан аймаг, дүүргийн НДХ	Илэрсэн төлбөр, зөрчлийн дүн /сая төг/
1	Архангай аймгийн НДХ	1,507.2	Төв аймгийн НДХ	178.3
2	Баянхонгор аймгийн НДХ	47.4	Сүхбаатар аймгийн НДХ	24.1
3	Увс аймгийн НДХ	1,470.5	Өвөрхангай аймгийн НДХ	0
4	Говь-Алтай аймгийн НДХ	14.1	БЗД-ийн НДХ	1,727.5
5	СХД-ийн НДХ	1,875.4		
Нийт дүн		4,914.6	Нийт дүн	1,929.9

Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, салбарын хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй холбоотой асуудлаар аймаг, орон нутагт 401, нийслэлд 503 зөрчлийн шинжтэй нийт 904 үйлдлийг шалгаж нийт 894 аж ахуйн нэгж, байгууллагад 1,155.8 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлэн нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсний 586.5 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг орон нутгийн НДХ-үүд, 568.2 сая төгрөгийн төлбөр, зөрчлийг дүүргийн НДХ хариуцан шийдвэрлэж, нийт төлбөр, зөрчлийн 79.2 хувь буюу 915.3 сая төгрөгийг барагдуулсан байна². Шалгалтад хамрагдсан 811 байгууллагад Зөрчлийн тухай хуулийн дагуу 203.0 сая төгрөгийн тorgууль оногдуулан 200.0 сая төгрөгийг барагдуулсан байна.

2021 онд хийсэн хяналт шалгалтаар 4,914.6 сая төгрөгийн, 2022 онд 1,929.9 сая төгрөгийн зөрчил илэрсний 95.0-98.9 хувь нь тэтгэврийн даатгалын сантай холбоотой зөрчил эзэлж байна. Уг зөрчлийг арилгах чиглэлээр холбогдох хууль тогтоомжийн дагуу акт тогтоож шаардлагатай арга хэмжээ авч ажиллаж байгаа хэдий ч зөрчил буурахгүй байна. Үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулж хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоосон, байцаагчийн буруугаас илүү тэтгэвэр, тэтгэмж тооцож олгосон, нярав, нягтлан бодогч нарын хувийн дансаар дамжуулан гүйлгээ хийсэн зэрэг зөрчилд холбогдох нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан тушаалтуудад тооцсон хариуцлага, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар тайланд тодорхой тусгаагүй байна.

Нийгмийн даатгалын салбарт бүтэц, зохион байгуулалтын өөрчлөлт хийх шаардлагатай байгаа талаар өмнөх оны тайланд тусгасан хэдий ч 2022 онд нийгмийн даатгалын байгууллагын тогтолцоог оновчтой болгох чиглэлээр өөрчлөлт хийгдээгүй байна.

Мөн НДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланд Нийгмийн даатгалын байгууллагад “Ёс зүйн хороо”-г байгуулж, нийгмийн хариуцлагатай байгууллага болон хөгжих, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, хяналт шалгалтын газрын бүтцийг өргөжүүлж, цахим хяналтын нэгж байгуулах чиглэлээр 2022 онд салбарын хэмжээнд анхаарч ажиллах талаар зорилт болгон тусгасан байсан хэдий ч тус зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажил хийгдсэн эсэх талаар тайланд дурдаагүй байна.

² 2022 оны 12 дугаар сарын 01-ний байдлаар

2.5.Эмнэлгэ хөдөлмөрийн магадлах комисс болон гомдлын шаардлагын зөвлөлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар түүнд хяналт тавих хүрээнд:

Засгийн газрын 2022 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн 266 дугаар тогтоолоор баталсан “Гомдлын шаардлагын зөвлөлийн дүрэм”-ийн 2.2, 2.4 дэх хэсэгт заасны дагуу НДЕГ-ын даргын 2022 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/129 дүгээр тушаалаар НДЕГ-ын дэргэдэх Гомдлын шаардлагын төв зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан байна. Тус зөвлөл нь 2022 онд 4 удаа хуралдаж, нийт 31 иргэний асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

Мөн НДЕГ-ын даргын 2022 оны А/132 дугаар тушаалаар аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх гомдлын шаардлагын салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан байна.

Аймаг, дүүргийн НДХ-ийн дэргэдэх Гомдлын шаардлагын салбар зөвлөл 4 удаа хуралдаж, нийт 362 иргэний өргөдөл гомдлыг хэлэлцэн, 265 иргэний хүсэлтийг ханган шийдвэрлэж, 90 иргэний хүсэлтийг хууль тогтоомжийн заалтыг хангахгүй гэж үзэн татгалзсан, мөн 7 иргэнээс нэмэлт баримт бүрдүүлж дахин хэлэлцэхээр шийдвэрлэсэн байна.

2022 онд улсын хэмжээнд хөдөлмөрийн чадварын алдалтын хувь, хугацаа тогтоолгосон нийт 103,235 иргэн байгаагаас НДС-аас 64,717 иргэн, Нийгмийн халамжийн сан /цаашид “НХС”/-аас 38,518 иргэн байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Үүнээс: Нийслэлийн хэмжээнд 39,586 (38.4%) иргэн, орон нутгийн хэмжээнд 63,649 (61.6%) иргэн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгожээ. Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг шинээр тогтоолгосон 9,778, сунгуулсан 93,475, цуцуулсан 9,294, нас барсан 2,461, хөдөлмөрийн нөхцөл сольсон 82, ажлын цаг хорогдуулсан 4 иргэн байна.

2022 онд нийт 5 удаагийн дахин магадлалаар Сүхбаатар дүүрэг, Говь-Сүмбэр, Дорнговь, Баянхонгор, Сүхбаатар, Баян-Өлгий аймгуудад 1,406 иргэнийг дахин магадалж үүнээс: 1,025 (79.2%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг хэвээр магадлан, 332 (26.3%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын заалт, хувь, хугацааг өөрчилж, 49 (4%) иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцлахаар шийдвэрлэсэн байна.

Мөн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа тогтоолгосон даатгуулагчийн тоогоор улсын дундаж (3.2)-аас өндөр байгаа Ховд, Архангай, Дорнод аймгуудад Эрүүл мэндийн яамны мэргэжлийн салбар зөвлөлүүдтэй хамтарсан магадлал хийж, нийт 2,493 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоосон байдалд хяналт шалгалах хийж, 1,430 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг хэвээр магадлан, 223 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацааг цуцалж, 773 даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, заалт, оношийг тус тус өөрчилж магадалсан байна.

2.6.Нийгмийн даатгал, эмнэлгэ хөдөлмөрийн магадлагааны асуудлаар иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг барагдуулах хүрээнд:

Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 214 дүгээр захирамжийн дагуу өргөдөл, гомдол шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах зорилгоор иргэд, даатгуулагч, байгууллага, ажил олгогчоос нийгмийн даатгалын байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд судлан үзэж, шуурхай шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан ажиллаж, 2022 онд нийт 236 өргөдөл, гомдол ирснийг шийдвэрлэн ажилласан талаар тайланд дурдсан байна.

Гэвч тайланд тус ажлын хэсгийн ажилласан үр дүн, шийдвэрлэлтийн дүн мэдээ, үүсэж байгаа асуудлын талаар нэгтгэн дүгнэсэн мэдээг тусгаагүй байна. Түүнчлэн нийгмийн

даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчний хангарт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргах, энэ талаар холбогдох арга хэмжээ авах болон нийгмийн даатгалын асуудлаар журам, зөвлөмж гаргах чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой ажил хийгдээгүй байна.

Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих чиг үүргийн хэрэгжилтийг Нийгмийн даатгалын сангийн төсөв, төсвийн гүйцэтгэл бүлгээс харна уу.

ГУРАВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСӨВ, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЛААР

3.1.Нийгмийн даатгалын сангийн орлого:

Улсын Их Хурлаас 2021 оны 11 дүгээр сарын 12-ны өдөр баталсан Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай хуулиар тус сангийн орлого, зарлагыг дараах байдлаар баталжээ.


Хүснэгт 3.Нийгмийн даатгалын сангийн 2022 оны орлого, зарлага

НДС-ийн орлого	Тэрбум төгрөг	НДС-ийн зарлага	Тэрбум төгрөг
Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	2,379.9	Тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд	3,403.4
ЭМДС-аас санхүүжих	1.1	НДБ-ын үйл ажиллагааны зардалд	32.2
Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг	920.9	НДШ-ийн 50 хувийн буцаан олголтод	150.8
Нийт орлого	3,301.9	Нийт зарлага	3,511.7


Харин Сангийн сайдын 2022 оны “Төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай” 239 дүгээр тушаалын 8 дугаар хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн сар, улирлын хуваарь”-ийн дагуу улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 920.9 тэрбум төгрөгөөр баталсныг 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж 844.7 тэрбум төгрөг, мөн “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хуулийн дагуу даатгуулагчаас төлсөн нийгмийн даатгалын шимтгэлийн 50 хувийн буцаан олголтод 150.8 тэрбум төгрөгийг баталсан боловч 76.1 тэрбум төгрөгөөр бууруулж 74.7 тэрбум төгрөгөөр тус баталсан байна.

НДС-ийн орлого бүрдүүлэлтэд шимтгэлийн орлого, тэр дундаа тэтгэврийн даатгалын сан томоохон үүрэг гүйцэтгэж, шимтгэлийн орлого тасралтгүй нэмэгдэж ирсэн. Тухайлбал, Зураг 2-т үзүүлснээр 2019-2022 онуудад НДС-ийн нийт орлогын 78.2-86.4 хувийг тэтгэврийн даатгалын сангийн орлого бүрдүүлж байна.

Зураг 2. Нийгмийн даатгалын сангийн орлогын бүрдэлт



Зураг 3. НДС-ийн 201-2022 оны батлагдсан төсөв



2022 онд НДС-ийн орлого 3,512.5 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 780.5 (28.6%) тэрбум төгрөгөөр өссөн нь тэтгэврийн даатгалын сангийн орлого 652.5 (21.7%) тэрбум төгрөгөөр, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангийн орлого 79.6 (61.6%) тэрбум төгрөгөөр, тэтгэмжийн даатгалын сангийн орлого 56.8 (31.5%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Түүнчлэн НДС-ийн орлого өсөхөд албан журмын даатгуулагчдын тоо өмнөх оноос 8.2 хувиар буюу 90,433-аар нэмэгдсэн нь нөлөөлсөн байна.

2020-2022 онуудад НДС-ийн зарлага, орлогоосоо 195.6-681.8 тэрбум төгрөгөөр давж, алдагдалтай батлагдаж иржээ. 2022 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн орлого 2,379.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 2,668.6³ тэрбум төгрөгийг төвлөрүүлж, давхардсан тоогоор 2,868.1 мянган хүнд 3,415.7 тэрбум төгрөгийг тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд зарцуулжээ. “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд НДС-аар 2022 онд үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оноос 2,008.2 мянга буюу 70.2 хувиар өссөн байна.

Мөн НДС-ийн нийт орлогын 55.1 хувь буюу 1,471.6 тэрбум төгрөгийг ажил олгогч, 44.3 хувь буюу 1,182.2 тэрбум төгрөгийг даатгуулагчийн төлсөн шимтгэл, 0.6 хувь буюу 14.8 тэрбум төгрөгийг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний улмаас тахир дутуу болсон даатгуулагчийн шимтгэлийн орлого болон бусад орлого эзэлж байна.

³ Тус дунд ЭМДС-аас санхүүжих 1.1 тэрбум, улсын төсвээс олгох 844.7 тэрбум төгрөгийн санхүүгийн дэмжлэг ороогүй болно.


3.2. Нийгмийн даатгалын сангийн зарлага:

2022 оны байдлаар НДС-аас 473.8 мянган иргэн тэтгэвэр авч байгаагийн 79.5 хувь нь өндөр насын, 10.5 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн, 3.4 хувь нь тэжээгчээ алдсаны, 6.6 хувь нь цэргийн тэтгэвэр тус тус авч байна. Эдгээрт 2022 онд тэтгэврийн даатгалын сангаас нийт 3,031.3 тэрбум төгрөгийн тэтгэвэр олгосон байна.

2022 онд НДС-аас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд зарцуулсан зардлыг авч үзвэл:

- 372.0 мянган даатгуулагч өндөр насын тэтгэвэрт 2,408.0 тэрбум төгрөг;
- 19.6 мянган даатгуулагчийн гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүдийн тэжээгчээ алдсаны тэтгэврийн зардалд 103.7 тэрбум төгрөг;
- 7.2 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжид 36.0 тэрбум төгрөг;
- 58.5 мянган даатгуулагч эх жирэмсний болон амаржсаны тэтгэмжид 121.1 тэрбум төгрөг;
- 30.5 мянган даатгуулагч ажилгүйдлийн тэтгэмжид 78.6 тэрбум төгрөг;
- 6.2 мянган даатгуулагч тахир дутуугийн тэтгэвэрт 316.7 тэрбум төгрөг;
- 14.2 мянган даатгуулагчийн ар гэрт оршуулгын тэтгэмжийн зардалд 14.2 тэрбум төгрөг;
- 0.01 мянган даатгуулагч хөдөлмөрийн чадвараа нөхөн сэргээхтэй холбоотой төлбөр, зардал, хөнгөлөлт, шимтгэлийн зардалд 10 сая төгрөгийг тус тус олгосон байна.

Зураг 4. Нийгмийн даатгалын сангийн зарлага



Ажилгүйдлийн даатгалын сангийн орлогод 2022 онд 53.6 тэрбум төгрөг төвлөрч, тус сангаас 30.5 мянган даатгуулагчид 78.7 тэрбум төгрөгийн ажилгүйдлийн тэтгэмж авсан байна. Мөн ажилгүйдлийн даатгалын сангаас тэтгэвэр авагчдын тоо 4.3 мянган хүнээр өсөж, түүнд зарцуулсан тэтгэмжийн хэмжээ 21.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

НДС-аар үйлчлүүлсэн иргэдийн тоо өмнөх оныхоос 2,008.2 мянга буюу 70.2 хувиар өссөн нь “Нийгмийн даатгалын шимтгэлээ өөрөө хариуцан төлсөн зарим даатгуулагчийн шимтгэлийн 50 хувийг буцаан олгох тухай” хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд давхардсан тоогоор 2,087.7 мянган даатгуулагчдад 72.7 тэрбум төгрөгийг олгосонтой холбоотой байна. Мөн үүнтэй холбогдуулан Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал 4.6 тэрбум төгрөг буюу 17.3 хувиар өссөн гэж тайлгагнасан байна.

Хүснэгт 4. Нийгмийн даатгалын сангийн зарлага

Зарлагын төрөл	2017 он	2018 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
Тэрбум төгрөг						
НИЙТ	1 890.9	1 814.6	2 062.3	2 451.8	2 535.8	3 414.0
Урсгал зардал	1 890.9	1 814.6	2 062.3	2 451.8	2 565.6	3 415.7
Бараа, үйлчилгээний зардал	20.1	18.4	23.4	25.9	25.8	30.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	15	13.3	16.7	19.0	18.9	20.6
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	1.7	1.5	2.0	2.4	2.4	2.5
Бусад зардал	3.5	3.6	4.8	4.5	4.5	7.0
Татаас	91	-	-	-	-	-
Урсгал шилжүүлэг	1 779.7	1 796.2	2 038.8	2 425.9	2 539.8	3 385.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	196.7	-	-	-	-	-
Бусад урсгал шилжүүлэг	1 583.0	1 796.2	2 038.8	2 425.9	2 539.8	3 385.6
Хөрөнгийн зардал	-	-	-	-	-	-

Эх сурвалж: Сангийн яам

Нийгмийн даатгалын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг батлагдсанаас 31.2 тэрбум төгрөгийг зарцуулж, үүнээс Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд ажиллаж байгаа 1,416 ажилтан, албан хаагчдын цалин хөлс, Нийгмийн даатгалын шимтгэлд үйл ажиллагааны зардлын 74.0 хувь буюу 23.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Тэтгэврийн даатгалын сангийн зардал 99.2 хувь, тэтгэмжийн даатгалын сан 96.8 хувь, ҮОМШӨ-ний даатгалын сан 93.8 хувийн гүйцэтгэлтэй, даатгуулагчийн төлсөн шимтгэлийн 50.0 хувийн буцаалт 97.2 хувь, үйл ажиллагааны зардал 96.9 хувийн зарцуулалттай байна.

НДҮЗ-өөс ирүүлсэн мэдээллээр арилжааны банкууд дахь НДС-ийн мөнгөн хөрөнгө 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар 991.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 5. Нийгмийн даатгалын сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл, тэрбум.төг

	Банкны нэр	Харилцахын үлдэгдэл
1	Голомт банк	49.6
2	Капитрон банк	9.15
3	Төрийн банк	265.7
4	Төрийн сан	244.6
5	Хаан банк	303.7
6	Хас банк	1.9
7	Худалдаа хөгжлийн банк	20.7
8	БНСҮ-ын Үрий банк	0.09
9	Чингис хаан банк	96.1
Нийт дүн		991.6
Капитал банкнаас авах авлага		69.2

Эх үүсвэр: НДҮЗ-өөс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахимаар ирүүлсэн мэдээллээс

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар арилжааны 9 банканд 991.6 тэрбум төгрөгийн харилцах дансны үлдэгдэлтэй, төрийн санд 244.6 тэрбум төгрөг төвлөрүүлсэн байна.

НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд 2021 оны аудитын дүгнэлтээр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах талаар гүйцэтгэсэн ажлын талаарх мэдээлэл тусгагдаагүй байна.

Харин Үндэсний аудитын газраас НДС-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд өмнөх оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар тогтоосон албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт 71.4 хувтай байна гэж дурдсан байна.

Хүснэгт 6.Аудитын зөвлөмж, шаардлагын хэрэгжилт

	Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
		тоо	дүн	тоо	дүн	хувь
1	Албан шаардлага	4	112,837.4	3	85,739.9	75.0
2	Зөвлөмж	3	3.5	2	3.5	66.7
	Нийт дүн	7	112,840.9	5	85,743.4	71.4

ДӨРӨВ.НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ӨР АВЛАГЫГ БАРАГДУУЛАХ ХҮРЭЭНД:

4.1.Капитал банкны өр авлагыг барагдуулах хүрээнд:

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А/96 дугаар тушаалаар Капитал банкийг албадан татан буулгах шийдвэр гарч, “Капитал банк” ХХК дахь банкны эрх хүлээн авагчаас /цаашид “ЭХА” гэх/ 104.2 тэрбум төгрөг нэхэмжилсэн.

Банкны эрх хүлээн авагч томилогдоноос хойших хугацаанд төлбөр нэхэмжлэх, нэхэмжилсэн төлбөрийг төлүүлэх чиглэлээр НДҮЗ нь нийт 11 удаагийн хуралдаанаар 6 тогтоол баталжээ. Эрх бүхий байгууллагуудын шийдвэр, зөвшөөрлийн дагуу ЭХА-тай “өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх гэрээ”-г байгуулж, 25.0 тэрбум төгрөгийн 78 хөрөнгийг авч, санхүүгийн тайлан мэдээнд тусгасан байна.

Хүснэгт 7.Хөрөнгийн мэдээлэл

№	Хүлээн авсан хөрөнгө	Тоо	Мөнгөн дүн (сая төгрөг)
1	Газар, гарааштай газар	10	1,932.8
2	Орон сууц	28	5,253.4
3	Зоорь агуулах, үнээний зориулалттай ферм	14	580.0
4	Хувийн сууц, газар	4	75.4
5	Үйлдвэр, үйлчилгээ, оффисын зориулалттай хөрөнгө	10	11,977.3
6	Орон сууцнаас бусад /орон нутагт/	12	5,242.8
	Нийт дүн	78	25,061.7

Эх үүсвэр: НДҮЗ-өөс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахимаар ирүүлсэн мэдээллээс

2021 онд 22.1 тэрбум төгрөгийн 46 хөрөнгө, 2022 онд 2.9 тэрбум төгрөгийн 32 хөрөнгө буюу нийт 25.0 тэрбум төгрөгийн 78 хөрөнгийн 10-ыг буюу 11.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар /цаашид “ЭМДЕГ” гэх/-тай хамтран эзэмшиж байна.

Хүснэгт 8.ЭМДЕГ-тай хамtran эзэмшиж буй хөрөнгө (сая төгрөгөөр)

№	Хамтарсан хөрөнгө	Хөрөнгийн дүн	НДЕГ-т ногдох дүн (43.29%)
1	Үйлчилгээний зориулалттай барилга	562.5	243.5
2	Үйлчилгээний зориулалттай барилга	14,704.6	6,365.6
3	Үйлчилгээний зориулалттай барилга	2,591.6	1,121.9
4	Үйлчилгээний зориулалттай барилга	2,642.2	1,143.8
5	Үйлчилгээний зориулалттай барилга	4,018.5	1,739.6
6	Үйлчилгээний зориулалттай барилга	3,148.2	1,362.8
7	Үйлчилгээний зориулалттай барилга	27,667.6	11,977.2
8	Үйлчилгээний зориулалттай барилга		
9	Дуусаагүй барилга		
10	Дуусаагүй барилга		

Эх үүсвэр: НДҮЗ-өөс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахимаар ирүүлсэн мэдээллээс

Байнгын хорооны хуралдаанаар НДҮЗ-ийн 2021 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэх явцад дээрх хамtran эзэмшиж байгаа хөрөнгийн дуудлага худалдааг зохион байгуулах бэлтгэл ажлыг хангасан талаар тайлагнаж байсан. 2022 онд дуудлага худалдааг 3 удаа зохион байгуулсан боловч амжилтгүй болсон байна.

ЭХА-аас нийгмийн даатгалын санд 2020 онд 826.7 сая төгрөг, 2021 онд 7,223.4 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 22,156.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий 46 хөрөнгийг нийт 29,380.0 тэрбум төгрөгийн өр төлбөрт, 2022 онд 1,744.8 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905.1 тэрбум төгрөг бүхий 29 хөрөнгийг 4,649.9 тэрбум төгрөгийн өр төлбөрт, 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 150.0 сая төгрөгийн өр төлбөрийг тус тус барагдуулснаар 2023 оны 03 дугаар сарын 27-ны байдлаар 69.2 тэрбум төгрөгийн өр төлбөрийн үлдэгдэлтэй гэж тайлагнасан байна.

**Хүснэгт 9.Капитал банкнаас авах авлага болон дансны үлдэгдэл
(сая төгрөгөөр)**

№	Төрөл	Дансны үлдэгдэл 2019.04.08	Өр төлбөр барагдуулалт				Нийт дүн	Дансны үлдэгдэл 2023.03.27
			2020 он	2021 он	2022 он	2023 он		
1	Мөнгөн хэлбэрээр	104,206.7	826.7	7,223.4	1,744.8	150.0	9,944.9	69,200.1
2	Хөрөнгөөр		-	22,156.6	2,905.1	-	25,061.7	
Нийт дүн		104,206.7	826.7	29,380.0	4,649.9	150.0	35,006.6	69,200.1

Эх үүсвэр: НДҮЗ-өөс 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдөр цахимаар ирүүлсэн мэдээллээс

ҮАГ-аас хийсэн “Нийгмийн даатгалын сангийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-д Капитал банкнаас авах 73,999.9 сая төгрөгийн авлагаас тайлант онд 1,744.8 сая төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905.2 сая төгрөгийн 32 нэр төрлийн үл хөдлөх хөрөнгийг хүлээн авч, данс бүртгэлд тусгаж, жилийн эцсийн санхүүгийн тайланд 69,350.0 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд авлагыг үе шаттай барагдуулах, холбогдох төрийн байгууллагуудтай хамтарч ажиллах талаарх албан шаардлагыг хүргүүлсэн байна.

2022 онд ЭХА-аас 25.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 86 үл хөдлөх хөрөнгийг НДС-ийн нэхэмжилсэн өр төлбөрт суутган авах зөвшөөрлийг авсан боловч ЭМДЕГ дээрх хөрөнгүүдийг

мөн авахаар санал гаргасан тул харилцан тохиролцож 8.4 тэрбум төгрөгийн 22 хөрөнгийг сонгож, мөн 8.8 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 8 хөрөнгийг дахин үнэлгээ хийлгүүлэх хүсэлт гаргасан байна. Үнэлгээ өндөр 5.7 тэрбум төгрөгийн 25 хөрөнгийг 2 байгууллага “Хүлээн авахаас татгалзсан” гэх шалтгаанаар 2.9 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 32 хөрөнгийг хүлээн авчээ.

Мөн тайлант онд эдгээр хөрөнгүүдийг няглан бодох бүртгэлд бүртгэж, хөрөнгийн нээлттэй дуудлага худалдааг 9 удаа зохион байгуулж, 8.2 тэрбум төгрөгийн үнэлгээтэй 31 (нээлттэй дуудлага худалдаагаар 21 хөрөнгө, Худалдах, худалдан авах гэрээгээр 10 хөрөнгө) хөрөнгийг 8.4 тэрбум төгрөгөөр борлуулж НДС-д төвлөрүүлсэн байна.

(Нээлттэй дуудлага худалдааны болон худалдах, худалдан авах гэрээгээр зарсан хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралтаас үзнэ үү.)

Үйлдвэрлэл, үйлчилгээ явуулж байсан 34 аж ахуй нэгж, иргэнтэй түрээсийн гэрээг шинэчлэн байгуулж, 241.5 сая төгрөгийн түрээсийн орлогыг НДС-д төвлөрүүлэн хөрөнгийн ашиглалт, хамгаалалттай холбоотой 44.2 сая төгрөгийн зардал гарсан бол 2023 оны 04 дүгээр сарын 12-ны өдрийн байдлаар 47 хөрөнгө бүхий 16.8 тэрбум төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

4.2. Чингис хаан банк болон Үндэсний хөрөнгө оруулалтын банкны өр авлагыг барагдуулах хүрээнд:

НДС-ийн мөнгөн хөрөнгө байршиж буй Үндэсний хөрөнгө оруулалтын банк болон Чингис хаан банк нь Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1-т заасан “..... хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх” шаардлагыг 2019 оны 10 дугаар сараас эхлэн хангахгүй болсон талаар Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар НДҮЗ-ийн 2021 оны тайланг хэлэлцэх явцад хөндөгдөж байсан.

2021 оны 04 дүгээр сард Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд Үндэсний хөрөнгө оруулалтын банк дахь НДС-ийн мөнгөн хөрөнгө болох 5.3 тэрбум төгрөгийг гаргуулах тухай нэхэмжлэл гаргаж, улмаар 2021 онд харилцах дансны хүү болох 454.0 сая төгрөг, харилцах данснаас 5.82 тэрбум төгрөгийн төлбөрийг барагдуулж, 12.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсан. 2022 онд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны үлдэгдэл төлбөрийг бүрэн барагдуулж, мөн 34.3 сая төгрөгийн хүүгийн авлагыг гаргуулж дансыг хааснаар НДС-ийн мөнгөн хөрөнгийн авлагагүй болсон байна.

Харин Чингис хаан банканд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар 100.5 тэрбум төгрөгийн НДС-ийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байгаагаас тайлант хугацаанд 4.4 тэрбум төгрөгийн өр төлбөрийг барагдуулж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 96.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Монгол банкнаас тогтоосон банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаагүй Чингис хаан банканд байршиж буй дээрх 96.1 тэрбум төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг НДС-ийн төв санд буцаан төвлөрүүлээгүй, тус банктай 2021 онд байгуулсан “Төлбөр тооцооны үүрэг хэсэгчлэн гүйцэтгэх тухай” гэрээний үүргийг хангуулах, харилцахын үлдэгдлийг барагдуулж ажиллах талаар өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлээгүй гэсэн дүгнэлтийг Үндэсний аудитын газраас гаргасан байна.

НДҮЗ-ийн 2021 оны үл ажиллагааны тайланг Нийгмийн бодлогын байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүдээс “жил бүрийн эхэнд Үндэсний

зөвлөлүүдийн хуралдаанаар банканд байршуулах хадгаламжийн дээд хэмжээ, хүүгийн түвшинг банк тус бүрээр батлах, тухайн банканд байршуулах хадгаламжийн хэмжээ, хүүгийн хувийг тогтоохдоо банкны зохистой харьцааг хангаж байгаа эсэх, активын хэмжээгээр эрсдэл даах чадвар, ашиг, алдагдлын хэмжээг тооцдог байх” зэрэг санал, зөвлөмжийг өгч байсан.

Харин 2022 онд НДС-ийн хөрөнгийг арилжааны банканд хадгаламж хэлбэрээр байршуулах журмын 3.4.1-д “хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн тухайн жилийн дээд хэмжээг тооцоолон, эхний улиралд багтаан НДҮЗ-өөр хэлэлцүүлнэ.” гэж заасны дагуу холбогдох санал, танилцуулга, тооцоолол, хамтарсан шийдвэрийн төслийг НДҮЗ-ийн хуралдаанаар хэлэлцэн Сангийн яам болон Монголбанканд санал хүргүүлсэн боловч Сангийн яамнаас татгалзсан хариу ирүүлсэн учир хугацаатай хадгаламж хэлбэрээр байршуулах хөрөнгийн хэмжээ батлагдаагүй байна.

ТАВ.НДҮЗ НЬ ҮЙЛ АЖИЛЛАГААНДАА СИСТЕМЧИЛСЭН ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЭСЭХ ТАЛААР

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолоор Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагуудад үйл ажиллагааны тайлангаа Улсын Их Хуралд ирүүлэхдээ “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж ирүүлэх үүрэг өгсний дагуу НДҮЗ нь 2022 оны үйл ажиллагааны системчилсэн үнэлгээний тайланг ирүүлсэн байна.

Системчилсэн үнэлгээний зорилго нь байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж, өөрийн тавьсан зорилгодоо ямар хэмжээнд хүрсэн байдлыг тодорхойлох буюу тухайн байгууллагын дотоод үйл ажиллагааг үнэлгэхэд чиглэгддэг.

НДҮЗ нь системчилсэн үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлоходоо байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө, санхүү оновчтой болсон эсэхийг тогтоох шаардлагын үүднээс үнэлгээг хийсэн бол үнэлгээний зорилгоо байгууллагын үйл ажиллагааны үр өгөөж өөрийн тавьсан зорилгодоо хүрсэн байдлыг тодорхойлоход чиглэж, дотоодын буюу өөрийн үнэлгээний хэлбэрийг сонгож байгууллагын чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, НДҮЗ-ийн үйл ажиллагаа болон үндсэн үйл ажиллагааны чиглэлээр үнэлгээ хийсэн байна.

Байгууллагын үндсэн үйл ажиллагааг үнэлгэхдээ НДС-ийн төсөв, түүний гүйцэтгэлд голчлон анхаарч, даатгалын хамралт, даатгалын хяналт, Нийгмийн даатгалын үйлчилгээний цахимжилт, хүртээмж, лавлах үйлчилгээ, гадаад харилцаа, сургалт, сурталчилгааны талаар тайланд дурдсан гол тоон үзүүлэлтийн мэдээллийг харуулж, салбарын эрх зүйн орчны үнэлгээгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийн үнэлгээг харуулахаас гадна тухайн онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний ололтой талыг илрүүлсэн байна. Түүнчлэн уг системчилсэн үнэлгээний тайланд өнөөгийн нөхцөл байдалд хийх дүн шинжилгээгээр гаргаж, цаашдын бодлого чиглэл, 2023 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон байна.⁴ Гэвч жил бурийн системчилсэн үнэлгээний тайланд ирэх жилийн зорилго, чиглэл, хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлдог боловч энэ талаар хийсэн ажлын талаар тодорхой мэдээллийг тайланд тусгахгүй байх, бодит ажил хэрэг болгон хэрэгжүүлэхгүй байна.

Системчилсэн үнэлгээний тайлангаас үзэхэд тухайн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг задлан шинжилж, харьцуулах, тулгарч байгаа асуудлыг илрүүлэх, шалтгаан

⁴ Системчилсэн үнэлгээгээр үйл ажиллагааны хэрэгжилтийн үр дунг судалж, чиг үүргийг агуулгын хувьд нягталж, тэдгээрийг харьцуулах, задлан шинжлэх ажиллагааг хийдэг. “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны үр дунг үнэлгэхдээ төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн биелэлт, байгууллагын ил тод байдлын үнэлгээ, шилэн дансны хөтлөлт, байгууллагын шударга байдлын үнэлгээ, салбарын хөгжлийн үзүүлэлт зэрэг үзүүлэлтийг гол хэмжүүр болгон ашиглагдаг.

нөхцөлийг тодруулах, шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох, үйл ажиллагааны зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг системчилсэн үнэлгээний аргачлалын дагуу дүн шинжилгээ хийгдээгүй, системчилсэн үнэлгээнд тусгах шаардлагатай асуудлыг бүрэн тусгаагүй, хэт өрөнхий мэдээлэл агуулсан байна.

Системчилсэн үнэлгээний шалтгааныг байгууллагын үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгө санхүү, оновчтой болсон, зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоох гэж тодорхойлсон боловч “Нийгмийн даатгалын байгууллагын 2022 оны үйл ажиллагааны зардалд 32.2 тэрбум төгрөг батлагдсанаас 31.2 тэрбум төгрөгийг зарцуулж, 1.0 тэрбум төгрөгийг хэмнэж, нийт урсгал зардлын 74.0 хувь буюу 23.1 тэрбум төгрөгийг нийгмийн даатгалын салбарын ажилтан, албан хаагчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд зарцуулав.” гэх байдлаар тайлагнасан нь зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зорилгоор хийгдсэн үнэлгээний үнэлэлт, дүгнэлт өгсөн дүн шинжилгээ болоогүй байна.

2022 онд НДҮЗ нь бодлогын баримт бичиг, салбарын үндэсний хөтөлбөр, стратеги төлөвлөгөөний зорилтыг удирдлага болгон 67 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, төлөвлөгөөний гүйцэтгэлд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээгээр 94.8 хувийн хэрэгжилттэй гарсан байна. Хэрэгжүүлсэн нийт арга хэмжээний зорилт, арга хэмжээ нь зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн 100 хувийн хэрэгжилттэй 48, зорилт, арга хэмжээний хүрэх түвшинд бүрэн хүрээгүй боловч зохион байгуулалтын арга хэмжээ бүрэн авагдсан 90.0-99.4 хувийн хэрэгжилттэй 10, тавьсан зорилт, арга хэмжээнд хүрэх зорилгоор өөрсдөөс хамаарах шийдвэрийг гаргасан, гүйцэтгэл нь 70.0-74.0 хувийн хэрэгжилттэй 8 арга хэмжээ байна.⁵

Үйл ажиллагааны тайлангаас үзэхэд ололт дэвшилттэй, үр дүнтэй, бүрэн хэрэгжсэн арга хэмжээнүүдийг голчлон тайлагнасан бөгөөд хэрэгжилт хангалтгүй, удааширсан арга хэмжээний шалтгаан нөхцөлийг тодорхойлоогүй, салбарын хэмжээнд тулгарч байгаа асуудал, хүндрэл бэрхшээл, хүний нөөцийн хэрэгцээ шаардлага зэргийн талаар тайлагнаж ирүүлээгүй байна.

Цаашид НДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.4-д заасан “Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчиний хангарт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж, холбогдох арга хэмжээ авах” бүрэн эрхийнхээ хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээг сонсох, түүнд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг авч ажиллах шаардлагатай байна.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу холбогдох мэдээллийг байршуулах үүрэгтэй.

Энэ хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагын хэмжээнд шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын 33 байгууллага, НДС-ийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр хандан НДС-ийн болон байгууллагын шилэн дансны мэдээллийг төсөв, гүйцэтгэлийн 9, хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалтын 5, бусад 7, нийт 21 төрлийн мэдээллийг байршуулсан байна. Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд 2022 онд нийт 10,069 мэдээллийг байршуулахаас 10,040 мэдээллийг байршуулж мэдээлэл байршуулалт 99.7 хувьтай байна, эдгээрээс хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл 475, мэдээлээгүй 29 мэдээлэл байгаа талаар тайланд дурджээ.

Үндэсний аудитын газраас 2022 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтээр НДҮЗ-ийн даргын эрхлэх асуудлын хүрээний 16 байгууллага 2022 оны жилийн эцсийн байдлаар шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг Шилэн дансны тухай

⁵ НДҮЗ-ийн 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайлан.

хуулийн 4 болон 6 дугаар зүйлд заасны дагуу байршуулаагүйгээс 3,802.4 сая төгрөгийн 8 албан шаардлага, 183.6 сая төгрөгийн 8 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Мөн Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор НДҮЗ-ийн даргын эрхлэх асуудлын хүрээний 29 байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, 7 байгууллагад хуулийн зарим заалтыг хэрэгжүүлээгүй зөрчилд 0.6 сая төгрөгийн 1 төлбөрийн акт, 11.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 10.6 сая төгрөгийн 3 зөвлөмжийг ҮАГ-аас хүргүүлсэн байна.

ЗУРГАА. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 112 дугаар зүйлийн 112.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны “Системчилсэн үнэлгээ хийх тухай” 05 дугаар тогтоолд тус тус заасны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийж, дараах дүгнэлт, зөвлөмжийг хүргүүлж байна.

Дүгнэлт

1. Засгийн газрын 2022 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” 63 дугаар тогтоолын дагуу Нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн дагуу олгож байгаа тэтгэврийн хэмжээг 15 хувиар нэмэгдүүлэн бүрэн тэтгэврийн доод хэмжээг 500.0 мянган төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосноор дундаж тэтгэвэр 555.6 мянган төгрөгт хүрч, уг арга хэмжээнд 469.2 мянган тэтгэвэр авагч хамрагдсан байна.
2. Нийгмийн даатгалын 34 үйлчилгээнээс 2021 онд 18 үйлчилгээ, 2022 онд 6 үйлчилгээг цахимжуулснаар нийт 24 үйлчилгээ буюу 70.6 хувь нь бүрэн цахимжиж, төрийн болон даатгуулагч, иргэд, ажил олгогчдын цаг зав, хөрөнгийг хэмнэхээс гадна нийгмийн даатгалын үйлчилгээг түргэн шуурхай авах, ил тод байх боломжийг бүрдүүлсэн байна.
3. 2022 онд хийгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтаар үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулан хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр тогтоолгон авсан 86 хүнд холбогдох 1,834.0 сая төгрөг, байцаагчийн алдаанаас 61.9 сая төгрөгийг 103 хүнд илүү тооцож олгосон, 44.8 сая төгрөгийг 50 хүнд дутуу олгосон, ажилгүйдлийн даатгалын сангаас 44 хүнд 29.6 сая төгрөгийг үндэслэлгүйгээр олгосон, 1 хүнд 1.1 сая төгрөгийг дутуу олгосон зэрэг төлбөр, зөрчлийг илрүүлэн 698.5 сая төгрөгийн улсын байцаагчийн акт тогтоосноос 81.9 хувийг барагдуулсан байна.
4. 2022 онд Капитал банкны өр төлбөрийг барагдуулах хүрээнд 1,744.8 тэрбум төгрөгийг мөнгөн хэлбэрээр, 2,905.1 тэрбум төгрөг бүхий 29 хөрөнгийг 4,649.9 тэрбум төгрөгийн өр төлбөрт барагдуулж, 69.2 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй, Чингис хаан банкны өр төлбөрөөс 4.4 тэрбум төгрөгийг барагдуулж, 2022 оны жилийн эцсийн байдлаар 96.1 тэрбум төгрөгийн тус тус үлдэгдэлтэй байна. Харин Үндэсний хөрөнгө оруулалтын банканд НДС-ийн 12.4 сая төгрөг, мөн 34.3 сая төгрөгийн хүүгийн авлагыг бүрэн барагдуулжээ.
5. НДҮЗ нь 2022 оны үйл ажиллагааны тайландаа Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу системчилсэн үнэлгээ хийж ирүүлсэн боловч тухайн байгууллагын чиг үүргийн хэрэгжилтийг задлан шинжилж, харьцуулах, тулгарч байгаа асуудлыг илрүүлэх, шалтгаан нөхцөлийг тодруулах, шаардлагатай хүний

нөөцийг тодорхойлох, үйл ажиллагааны зардлын үр өгөөжийг дээшлүүлэх зэрэг системчилсэн үнэлгээний аргачлалын дагуу дүн шинжилгээ хийгдээгүй, шаардлагатай асуудлыг бүрэн тусгаагүй, хэт өрөнхий агуулгаар хийсэн нь тавьсан зорилгоо хангаагүй байна.

6. НДҮЗ-ийн 2022 оны үйл ажиллагааны тайланд Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл тусгагдаагүй байна.

Зөвлөмж

1. Тэтгэврийн даатгалын сан болон ажилгүйдлийн даатгалын сангаас үндэслэлгүй баримтаар шүүхийн шийдвэр гаргуулсан, хуурамч архивын лавлагаа гаргуулж хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насын тэтгэвэр тогтоолгосон зэрэг төлөвлөгөөт хяналт шалгалтаар илэрч байгаа зөрчлүүдийг бууруулах талаар үе шаттай арга хэмжээг авч ажиллахад анхаарах;
2. Үйл ажиллагааны тайланд шинжилгээ хийх явцад Нийгмийн даатгалын өрөнхий газар болон Үндэсний статистикийн хорооноос гаргасан зарим статистик тоо мэдээ (даатгуулагчдын тоо, албан болон сайн дурын даатгуулагчид) зөрүүтэй байна. Иймд тоо мэдээллийн зөрүү арилгах, нэгдсэн аргачлалаар статистик тоо мэдээллийг гаргах талаар судлан шийдвэрлэх;
3. Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах чиглэлээр 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгах, хийгдсэн ажлын үр дүнгийн талаарх мэдээллийг тухайн оны үйл ажиллагааны тайланд тусгаж, аудитын тайлангаар өгсөн шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэх;
4. НДҮЗ нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3.4-д заасан “Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, боловсон хүчний хангарт, санхүүгийн асуудлаар нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээллийг сонсон хэлэлцэж, санал дүгнэлт гаргаж, холбогдох арга хэмжээ авах” бүрэн эрхийнхээ хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын тайлан мэдээг сонсох, түүнд дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээг цаашид авч ажиллах;
5. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-т заасан үйл ажиллагааны тайланг Улсын Их Хуралд ирүүлэхдээ хуулиар олгосон бүрэн эрх, чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг иж бүрэн ирүүлж, үйл ажиллагааны үр дүнд суурилсан байдлаар тайлагнах, хууль тогтоомжоор олгосон чиг үүрэг болон тогтоол шийдвэрийг хэрэгжүүлснээр гарсан ээрэг болон сөрөг үр дүнг тайлагнаж ирүүлэх шаардлагатай байна.

--- оОо---

НЭЭЛТТЭЙ ДУУДЛАГА ХУДАЛДААНЫ МЭДЭЭЛЭЛ
(сая төгрөгөөр)

№	Хөрөнгийн мэдээлэл			Борлуулсан хөрөнгө		
	Огноо	Тоо	Мөнгөн дүн	Тоо	ЭХА-аас авсан дүнгээр	Борлуулсан дүнгээр
1	2022.01.06	12	5,358.6	8	3,041.1	3,110.5
2	2022.03.23	10	12,223.6		Оролцогч байхгүй	
3	2022.04.28	10	12,223.6		Оролцогч байхгүй	
4	2022.06.02	10	12,223.6		Оролцогч байхгүй	
5	2022.06.28	32	4,926.2	4	1,122.6	1,154.5
6	2022.08.17	17	6,107.5	5	1,005.37	1,033.68
7	2022.09.27	40	5,080.8	1	179.8	210.5
8	2022.11.08	35	3,367.4	2	729.8	754.7
9	2023.01.20	37	3,306.7	1	76.09	76.9
Дүн			21	6,153.56	6,340.9	

Худалдах, худалдан авах гэрээгээр зарсан хөрөнгийн мэдээлэл
(сая төгрөгөөр)

№	Огноо	Хөрөнгийн мэдээлэл		Үнийн дүн
1	2022.07.08	НД 89/22	Орон сууц	199.3
2	2022.07.08	НД 90/22	Орон сууц	194.6
3	2022.07.08	НД 91/22	Орон сууц	199.3
4	2022.07.08	НД 92/22	Орон сууц	179.4
5	2022.06.23	НД 94/22	Орон сууц	242.3
6	2022.06.23	НД 95/22	Орон сууц	179.4
7	2022.08.22	НД101/22	Орон сууц	242.3
8	2022.08.22	НД102/22	Орон сууц	199.3
9	2022.08.22	НД103/22	Орон сууц	194.6
10	2022.09.05	НД106/22	Орон сууц	242.2
Дүн				2,072.7
Нийт дүн				8,413.6